



ЭРҮҮЛ МЭНД

НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ



2025 оны жилийн эцсийн байдлаар нийт халдварт өвчний 92%-г цочмог халдварт өвчин, 5%-г БЗДХ, 3%-г сүрьеэ өвчин тус тус эзэлж байна.




2025 оны жилийн эцсийн байдлаар зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдвар 10000 хүн амд 14.6 промилль байна.



ХҮН АМ

2025 оны жилийн эцсийн байдлаар Баянзүрх дүүрэгт 6073 хүүхэд шинээр мэндэлж, төрөлтийн түвшин 13,5 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.9-өөр буурсан байна.



2025 оны жилийн эцсийн байдлаар нас баралт 1760 бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2-оор (0,1%) нэмэгдсэн байна.

Жирэмсний эрт хяналтын хувь 91,2% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1-ээр буурсан байна.

№	Эрт илрүүлгийн үзлэг	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь
1	Артерийн гипертензи /18+/ 1	270819	199999	73,8%
2	Чихрийн шижин хэв шинж -2 /35+/ 2	172708	154388	89,4%
3	Элэг /40+/ 3	131007	60012	45,8%
3	Хөхний хавдрын үзлэг /30-60нас/ 3	93378	83583	86,2%
4	Умайн хүзүүний эрт илрүүлэг /30+ 3,3 насаар/ 4	32875	9977	29,2%



ТӨРСӨН ХҮҮХЭД



Дүүргийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 6003 эх амаржин, 6073 хүүхэд шинээр мэндэлж, амьгүй төрөлтийн 17 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 2,8 промилль байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 тохиолдлоор буюу 2,0 промилоор буурсан байна. Эхийн эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдсэн бол Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 90 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 тохиолдлоор (2.2 промилль) нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ



ЭХИЙН ТӨРӨЛТ



Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 498-аар буюу 7,7 хувиар буурчээ. 2025 оны жилийн эцсийн байдлаар Гэрийн төрөлт 12 тохиолдол бүртгэгдэж нийт төрөлтийн 0.2 хувийг эзэлж байгаа бол хяналтгүй төрөлтийн 34 тохиолдол бүртгэгджээ.